БАТЛАВ:
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА Г.ГАНТУЛГА

# ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/Д | ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ | СУУРЬ ТҮВШИН | ЗОРИЛТОТ ТҮВШИН | ХУГАЦАА /Улирал/ | ХАРИУЦАГЧ |
|---|---|---|---|---|---|---|---|
| ЗОРИЛГО 1.ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ УДИРДАМЖ ЗААВРААР ХАНГАЖ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ САЙЖРУУЛНА. | | | | | | | |
| 1. | Зорилт 1.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах замаар зөрчлөөс урьдчилан сэргийлнэ. | 1.1.1.Албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг Ёс зүйн хорооноос баталсан аргачлалын дагуу гарган хэрэгжүүлнэ. | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | - | 1 | I | Ёс зүйн дэд хороо |
| 2. | Зорилт 1.4.Ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн төрийн байгууллагын соёлыг хэвшүүлнэ. | 1.4.3.байгууллага төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх, байгууллагын ёс зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр гаргасан ололт амжилтыг хөхиүлэн дэмжих, алдаршуулан олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлнэ. | Арга хэмжээний тоо | - | 1 | I-IV | Ёс зүйн дэд хороо |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | | 1.4.4.төрийн албан хаагч олон нийтийн санаа бодлыг сонсож, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн, иргэдэд хүндэтгэлтэй хандаж, иргэдийн итгэлийг хүлээхүйц харилцааны болон төрийн албаны нэр хүндэд нийцэхүйц соёлыг эзэмшинэ. | Арга хэмжээний тоо | - | 1 | I-IV | Ёс зүйн дэд хороо |
| ЗОРИЛГО 2.ТӨРИЙН АЛБАНД ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙГ ҮЛ ТЭВЧИХ СЭТГЭЛГЭЭ, ШУДАРГА БАЙДЛЫГ ЭРХЭМЛЭХЭД ЧИГЛЭСЭН СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛНЭ. | | | | | | | |
| 4. | Зорилт 2.1.Төрийн албан хаагч ёс зүйтэй ажиллахад дэмжлэг үзүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг идэвхжүүлнэ. | 2.1.1.Албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн ажлын байран дахь сургалтыг тогтмолжуулна. | Сургалтын тоо | - | 1 | I-IV | Ёс зүйн дэд хороо |
| 5. | | 2.1.3.байгууллага төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг ёс зүйн чиглүүлэх сургалтад хамруулж хэвшүүлнэ. | Шинээр томилогдсон албан хаагчийн тоогоор | - | Тухай бүр | I-IV | Ёс зүйн дэд хороо |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | | 2.1.4.ёс зүйн хариуцлага хүлээсэн төрийн албан хаагчийг танхимын давтан сургалтад хувийн зардлаар хамруулна. | Хариуцлага хүлээсэн албан хаагчийн тоогоор | - | Тухай бүр | I-IV | Ёс зүйн дэд хороо |
| 7. | Зорилт 2.2.Төрийн албан хаагч ёс зүйтэй ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлж, дэмжих арга хэрэгслийг өргөжүүлнэ. | 2.2.4.төрийн албан хаагч бүрийг ёс зүйтэй, шударга ажиллах үүргээ сайтар ухамсарлан ойлгож, чанд мөрдөхөд чиглүүлэн ёс зүйн асуудал хариуцсан албан тушаалтантай харилцах, холбогдох зөвлөгөөг авах талаарх мэдээллийг хүн бүрд хүргэх ажлыг байгууллага хэрэгжүүлнэ. | Арга хэмжээний тоо | - | 1 | I-IV | Ёс зүйн дэд хороо |
| ЗОРИЛГО 3.ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ САХИУЛАХ, ЗӨРЧЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛНА. | | | | | | | |
| 8. | Зорилт 3.3.Төрийн албанд ёс зүйн зөрчлийг мэдээлэх тогтолцоог бүрдүүлж, олон нийтийн хяналтыг идэвхжүүлнэ. | 3.3.1.байгууллага нь иргэн, албан хаагчаас төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гомдол, мэдээлэл хүлээн авч, ёс зүйн зөрчил хянан шийдвэрлэх үйл ажиллагааны мэдээ, тайланг олон нийтэд тогтмол мэдээлж хэвшинэ. | Хүлээн авсан гомдол мэдээллийн тоогоор | - | Тухай бүр | I-IV | Ёс зүйн дэд хороо |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ЗОРИЛГО 4.ЁС ЗҮЙТЭЙ ТӨРИЙН АЛБЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХЭД ИРГЭНИЙ НИЙГЭМ, ХУВИЙН ХЭВШИЛ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦООГ ХАНГАНА. | | | | | | | |
| 9. | Зорилт 4.3.Ёс зүйн чиглэлээр хөндлөнгийн хяналтыг хөхиүлэн дэмжинэ. | 4.3.4.байгууллага, томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг биелүүлэх чиглэлээр гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайланг жил бүр олон нийтэд мэдээлнэ. | Олон нийтэд мэдээлсэн тоо | - | 1 | I-IV | Ёс зүйн дэд хороо |

-oOo-

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

# БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН “ТАЙЛАНГИЙН МАЯГТ”[1]

**НЭГ. Товч танилцуулга[2]**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газар нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу нийт албан хаагчдыг саналыг үндэслэн тус газрын даргын 2024 оны 09 сарын 04-ний өдрийн А/105 дугаар тушаалаар Оюуны өмчийн газрын ёс зүйн дэд хороог 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тус газрын Ёс зүйн дэд хорооны даргаар Захиргаа удирдлагын газрын дарга Г.Гантулга, гишүүдээр Аж үйлдвэрийн өмчийн газрын бүтээгдэхүүний загварын ахлах шинжээч О.Оюунгэрэл, Зохиогчийн эрхийн газрын ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбаяр, Хяналт, шалгалтын газрын улсын байцаагч Б.Золбаяр, нарийн бичгийн даргаар Захиргаа удирдлагын газрын эрх зүй, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Далайцэрэн нар ажиллаж байна.

**ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд тогтоомжийн хэрэгжилтийн талаар**

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:

Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хөтөлбөрийн шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан. Мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрдлийн үнэлгээг хийж ажилласан болно.

1.Ёс зүйн хорооноос зохион байгуулсан ёс зүйн дэд хорооны гишүүдэд зориулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт” вебинар сургалт, “Ёс зүй ба хүний эрх” зорилтод сургалтад тус газрын ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд хамрагдсан.

2.Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран "Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс, зүй“ сэдэвт сургалтыг тус газрын албан хаагчид болон Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид, хамтын удирдлагын байгууллагын гишүүдэд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.




[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

3.Сэтгэл зүйч Ж.Үйлсттэй хамтран тус газрын албан хаагчдад “Стресс менежмент, ажлын байрны сэтгэл зүй” сэдвээр 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр сургалт зохион байгуулсан.



4.Залуусын цахим орчин дахь аюулгүй байдалд голлон анхаарч, технологийг аюулгүй, ёс зүйтэй ашиглахыг дэмжин, зорилгоор Монголын баримт шалгах төвийн ерөнхий эрхлэгч Э.Батцэцэг, баримт шалгагч, сэтгүүлч Г.Мөнхтунгалаг нартай хамтран 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Оюуны өмчийн газрын албан хаагчдад сургалт зохион байгуулсан.



2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

а). 2025 онд байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол мэдээлэл бүртгэгдээгүй бөгөөд нийт гомдол мэдээллийг https://www.ipom.gov.mn/mn.php?page=115 дамжуулан олон нийтэд мэдээлж байна.

б). Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг https://www.ipom.gov.mn/mn.php?page=155 цахим хуудсанд байршуулсан.

в). Шударга, ил тод, хариуцлагатай төрийн албаны соёлыг төлөвшүүлэн, ёс зүйн хэм хэмжээг сахих, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, ажлын байрны аливаа хэлбэрийн дарамтаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулж, албан хаагчид аливаа гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/118 дугаар тушаалаар Оюуны өмчийн газрын Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулж, “АРВАН ДӨРӨВ. АЛБАН ХААГЧААС ИРҮҮЛСЭН ГОМДОЛ МЭДЭЭЛЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ” бүлгийг нэмсэн.

г). Тус газрын даргын 2024 оны 09 сарын 04-ний өдрийн А/105 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн их үүсвэрийн шийдвэрлэсэн.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

а). “Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд Ёс зүйн дэд хорооны гишүүдийн бүртгэлийг хөтөлж, Монгол Улсын Ёс зүйн тухай хууль, холбогдох журам, Үндэсний хөтөлбөр зэргийг дотоод сүлжээгээр дамжуулан албан хаагчдад мэдээлсэн бөгөөд 2025 онд шинээр томилогдсон 1 албан хаагчид зөвлөмж боловсруулж танилцуулсан.

б). Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол мэдээлэл бүртгэгдээгүй.

в). Ёс зүйн чиглэлээр постер бэлтгэж олон нийтэд суртчилах ажлыг зохион байгуулсан.




| Гарсан үр дүн, ололт амжилт: | Бэрхшээл: |
|---|---|
| Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээлэл бүртгэгдээгүй, хянан шалгах чиг үүргийн хүрээнд холбогдох этгээдэд шилжүүлсэн гомдол мэдээлэл байхгүй.<br>2024 оны Шударга байдлын үнэлгээнд 81 байгууллага хамрагдсанаас "Оюуны өмчийн газар" тэргүүлсэн амжилт гаргасан. | Байхгүй. |
| Санал:Үгүй. | |

**Шалгах хэсэг:**

- ☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

**БАТАЛГААЖУУЛАЛТ:**

Томилох эрх бүхий албан тушаалтан
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГА /Г.ЭЛБЭГСАЙХАН/

Ёс зүйн дэд хорооны дарга
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА /Г.ГАНТУЛГА/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
ЭРХ ЗҮЙ, ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /Б.ДАЛАЙЦЭРЭН/

2026 оны 01 сарын 02-ны өдөр

**ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ "ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

| № | Үзүүлэлт | Шалгуур үзүүлэлт | | Авбал зохих оноо | Оноо | Хувийн жин |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт | Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлсан эсэх | | 1 | 1 | |
| 2 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх | | 1 | 1 | |
| 3 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал | Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх | 0.5 | 0.5 | |
| | | | Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал | 0.5 | 0.5 | |
| | | | Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал | 0.5 | 0.5 | |
| | | | Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал | 0.5 | 0.5 | |
| **Хэсгийн оноо** | | | | **4** | **4** | |
| | | | | | | |
| 4 | Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ) | Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх | | 1 | 0 | |
| 5 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал | | 1 | 1 | |
| 6 | | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал | | 1 | 1 | |
| **Хэсгийн оноо** | | | | **3** | **2** | |
| **Хэсгийн оноо** | | | | | | |
| 7 | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа | Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13] | | 1 | 1 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | (ЁЗДХ) | Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал (Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно) | 1 | 1 | |
| 9 | | Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал | 1 | 1 | |
| **Хэсгийн оноо** | | | **3** | **3** | |
| **Үнэлгээний нийт оноо, хувь** | | | **10** | **9** | |